



NFT Сангийн Танилцуулга

Бидэнтэй холбоо барих:

Утас: +976-75779444


И-мэйл: invest@orda.mn

Вэбсайт: www.orda.mn

Гарчиг

ОРДА-ын тухай.....	3
Хөрөнгө оруулалтын санал.....	4
NFT багцын хураангуй.....	5
Хөрөнгө оруулалтын хураангуй.....	6
NFT хөрөнгө оруулалт болох нь.....	9
NFT гэж юу вэ?.....	9
NFT урлагийн бүтээлийн салбарт.....	11
NFT видео тоглоомын салбарт.....	12
Санхүүгийн хураангуй.....	13
Хөрөнгө оруулалтын процесс.....	14
Хөрөнгө оруулалтаасаа хэрхэн гарах вэ?.....	15
Үйл ажиллагааны процесс ба бидний үйлчилгээ.....	15
Хууль эрх зүйн орчин болон эрдэлийн менежемент.....	16
Хууль эрх зүй татварын орчин.....	16
NFT хадгалалт.....	17
Манай баг.....	18
Түгээмэл асуултууд.....	20
Хөрөнгө оруулалтын анхааруулга.....	21
Хавсралт - 1. Санхүүгийн төсөөлөл.....	24

1 | ОРДА-ийн тухай



ОРДА бол хөрөнгө оруулагчдад хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, урлагийн бүтээл, ховор цуглуулгын зүйл зэрэг уламжлалт бус хөрөнгүүдийг (альтернатив хөрөнгө) хэсэгчилсэн байдлаар хөрөнгө оруулах боломж олгодог, технологид суурилсан платформ юм. Бид мэргэжлийн болон хувийн, уламжлалт болон уламжлалт бус хөрөнгө оруулалтын хоорондох заагийг арилган, хил дамнасан хөрөнгө оруулалтын татвар, хууль эрхзүйн аливаа хүндрэлүүдийг арилгаж, хөрөнгө, хөрөнгө оруулагч хоёрыг холбох гүүр болохоор зорин хөгжүүлэлтээ хийж байна.

Манай компанийн зорилго нь хөрөнгө оруулалтыг илүү хүртээмжтэй, эрх тэгш ардчилсан болгох бөгөөд өмнө нь зөвхөн мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон чинээлэг иргэдийн хөрөнгө оруулдаг байсан ховор бөгөөд тансаг виски, дарс, урлагийн сор бүтээл гэх мэт онцгой, уламжлалт бус хөрөнгүүдэд хүн бүр хөрөнгө оруулалт хийх боломжийг нэмэгдүүлэхэд оршино. Бид технологи болон инновацилаг бизнес загварын тусламжтайгаар хүмүүст тэр бүр нээлттэй биш байсан боломжуудыг нээж, өөрийн санхүүгийн бололцоондоо тохирсон хөрөнгө хуримтлуулах арга замыг бий болгож чадна гэж итгэдэг.

ОРДА нь хөрөнгийн зах зээлд энэхүү шинэлэг санаагаараа Цахиурын хөндийн нэр хүндтэй, олон улсын тэмцээнүүдийн нэг Startup Worldcup - т оролцож, бүсийн шилдэг 10 стартапын нэгээр шалгарсан бөгөөд БНСУ-ын засгийн газрын шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлдэг K-StartUp Grand Challenge 2021 хөтөлбөрийн шилдэг оролцогчдын нэгээр Монгол улсаас анх удаа амжилттай шалгараад байна.

Бид хөрөнгө оруулагчдадаа 2020 оны 3 дугаар сараас хойш дараах 6 төрлийн хөрөнгө оруулалтыг санал болгож амжилттай хэрэгжиж байна. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгө;
- Шотланд сингл молт торхтой виски;
- Дотоодын уран бүтээлчдийн сор бүтээлүүд;
- Хаалттай өрийн хэрэгсэл;
- Хандгайтай хамтарсан цуглуулагчийн буюу хязгаарлагдмал тооны дээд зэрэглэлийн Шотланд торхтой виски
- Алдарт “Brollach” лонхтой виски

Энэ удаа бид танд нэгэн өвөрмөц хөрөнгө оруулалтыг санал болгож байгаа нь NFT багц буюу өнөөгийн дэлхийн NFT-гийн зах зээл дээрх шилдэг, өндөр өгөөжтэй NFT-нүүдээс бүрдсэн багц хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн юм.

а. Хөрөнгө оруулалтын санал*

Анхны татан төвлөрүүлэх дүн \$30,000.00

Нэгжийн тоо 1,500.00

Нэгжийн үнэ \$20.00

в. NFT Багцын хураангуй

Компанийн нэр	“ORDA Дижитал ассет” ХХК
NFT төрөл	Урлагийн бүтээл, Видео тоглоом, Метаверс, Ховор цуглуулга
Буцаан худалдан авалт	Өмнөх сарын эцсийн цэвэр хөрөнгийн үнэлгээ дээр үндэслэн сар бүр буцаан худалдан авалт болон нэмэлт хөрөнгө оруулалт хийгдэнэ
Нэмэлт хөрөнгө оруулалт	
Зах зээл	Олон улсын болон дотоодын NFT зах зээл
Хугацаа	1 жил (Сунгах боломжтой)

**Хавсралт 1-ээс дэлгэрэнгүй тооцооллыг үзнэ үү.*

с. Хөрөнгө оруулалтын тойм

Бид та бүхэнд өнөөгийн хөрөнгө оруулалтын салбарын хамгийн шинэлэг ба тэсрэлттэй дижитал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн болох Non-Fungible Token буюу NFT зах зээлийн шилдэг NFT-нүүдээс бүрдсэн багц хөрөнгө оруулалтыг танилцуулж буйдаа таатай байна. NFT зах зээл нь блокчэйн технологийн тусламжтайгаар уламжлалт урлагийн зах зээлийг нэг шат ахиулаад зогсохгүй олон уран бүтээлч, дизайнер, видео тоглоом хөгжүүлэгч, мөн хөрөнгө оруулагчдын хоорондын худалдаа болон харилцааг хялбарчилснаар өнгөрсөн онд маш өндөр өгөөж хүртэж, олны анхаарлыг татсан билээ. Томоохон хөрөнгө оруулагчид болон шинжээчид NFT хөрөнгө оруулалт бол блокчэйн, крипто зах зээл болон метаверс зэрэгтэй хөл нийлүүлж буй, цаг үеийн хамгийн тохиромжтой хөрөнгө оруулалт мөн гэдгийг хүлээн зөвшөөрч, NFT зах зээлд аль хэдийн оролцох болжээ.

Энэхүү төслийн хүрээнд та NFT багцын хөрөнгө оруулагчдын нэг болж, манай мэргэжлийн баг хамт олны туслалцаатайгаар NFT ертөнцийн өгөөжийг олон улсын зах зээлээс хүртэх боломжтой болох юм.

ОРДА NFT Багцын тухай:

- Багцын тогтсон нийт дүн гэж байхгүй, өөрөөр хэлбэл нээлттэй бүтэцтэй багц тул та сар бүр багцад нэмэлтээр хөрөнгө оруулаад явах боломжтой.
- Манай мэргэжлийн баг зах зээлийн болон хөрөнгө оруулагчдын тооны өөрчлөлтөөс хамааран цаг тухай бүрт зохимжтой байдлаар багцыг удирдана.
- NFT Багц нь хөрөнгө оруулалтын нийт хэмжээнээс хамааран зах зээл дээрх хамгийн сайн үзүүлэлттэй 5-аас дээш NFT бүтээгдэхүүнээс бүрдэнэ.
- Багц нь урлагийн бүтээл, ховор цуглуулга, видео тоглоом болон метаверс зэрэг салбарын NFT-нүүдээс бүрдэнэ.
- Багцын нийт дүнгийн 20%-ийг үндэсний уран бүтээлч, хөгжүүлэгчдийг дэмжих, зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол NFT-нүүдэд хөрөнгө оруулна.



Хөрөнгө оруулалтын хуваарилалт

Урлагийн бүтээлийн NFT зах зээл нь хамгийн том бөгөөд түүхэн мэдээлэл ихтэй, мөн илүү өндөр өсөлт үзүүлэх чадамжтай тул багцын нийт дүнгийн 50%-ийг урлагийн NFT-нүүдэд хөрөнгө оруулна.

Видео тоглоом болон метаверс төрлийн NFT-нүүдийн хэрэгцээ болон эрэлт өндөр байдгаас гадна метаверс хөгжиж буйтай холбоотойгоор өндөр өсөлт үзүүлэх хүлээлттэй байгаа учраас багцын 30% нь видео тоглоом, метаверс төрлийн NFT-нүүдээс бүрдэнэ.

Ховор цуглуулгын төрөлд багцын хамгийн бага хувь буюу үлдсэн 20%-ийг хөрөнгө оруулах бөгөөд шалтгаан нь тус төрлийн NFT-нүүд маш ховор боловч тус зах зээлд тодорхой бус байдлын эрсдэл өндөр байгаад оршино.

Бид мөн Монголын NFT хөгжүүлэгч, уран бүтээлч нарыг дэмжих, зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор багцын 20-оос дээшгүй хувийг дотоодын зах зээл дээрх NFT-нүүдээс бүрдүүлнэ.



Энэхүү хөрөнгө оруулалтыг сонгох шалтгаанууд:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОНОВЧТОЙ ЦАГ ҮЕ:

NFT зах зээлийн орлого 2021 онд 41 тэрбум ам. доллар (крипто валютаар) хүрч, 2020 оны 100 саяас (крипто валютаар) 41,000% өсчээ. Ковид-19 цар тахлын нөхцөл байдал хөрөнгө оруулалтын салбарыг илүү хурдан, хялбар, найдвартай арга ашиглахад хүргэснээр блокчэйн дээр суурилсан NFT хөрөнгө оруулалтын зах зээлийг тэлэхэд томоохон нөлөө үзүүлсэн билээ.

ӨНДӨР ӨГӨӨЖ ХҮРТЭХ БОЛОМЖ:

Урлаг, ховор цуглуулга, мөн видео тоглоомын төрлийн NFT-нүүдийг оновчтой байдлаар удирдаж чадсан тохиолдолд 2-6 сарын хугацаанд дунджаар 30%-ийн өгөөж үзүүлжээ. Bored Ape Yacht Club, CryptoSkulls, Azuki гэх мэт дэлхийн зарим топ NFT-нүүд 100%-аас 20,000% хүртэлх өгөөж өгч чадсан нь мэдээж онцгой тохиолдлууд боловч NFT зах зээлд оновчтой хөрөнгө оруулснаар өндөр өгөөж хүртэх боломж байна. Гэвч энэхүү төрлийн хөрөнгүүд өгөөж өндөртэй ч, түүнийг дагаад эрсдэл нь ч өндөр гэдгийг дурьдах нь зүйтэй. Зах зээл дээр үнэ цэнэ нь унахаас гадна цахим халдлага, арилжааны платформуудын алдаа, буруу үнэ нийтлэх гэх мэтээс үүдэн хөрөнгө оруулалтын гарз хүлээсэн тохиолдлууд хэд хэд гарсан бөгөөд иймээс аль болох мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдээр дамжуулан хөрөнгө оруулах нь зүйтэй.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРӨЛЖҮҮЛЭЛТ:

Маш олон хөрөнгө оруулагчид тэсэрч буй NFT зах зээлд хөрөнгө оруулах тухай сонирхдог боловч хэрхэн зөв NFT сонгох, цаашлаад байнгын зах зээлийн судалгаа хийж, хөрөнгө оруулалтын багцаа удирдах завгүй, энэ нь зардал, мөн эрсдэл өндөртэй байдаг. Иймээс манай мэргэжлийн багийн тусламжтайгаар хөрөнгө оруулалтын багцаа олон төрлийн NFT бүтээгдэхүүнд тараан байршуулан эрсдэлийн менежмент хийхийн сацуу NFT зах зээлийн өгөөжөөс хүртэх боломжтой.

2 | NFT хөрөнгө оруулалт болох нь

NFT гэж юу вэ?

Non-Fungible Token буюу NFT гэдэг нь криптовалют ашиглан цахим ертөнцөд худалдагддаг өвөрмөц дижитал хөрөнгө юм. “Fungible” гэх англи үг нь “орлох боломжтой” гэсэн үг ба өөрөөр хэлбэл аливаа хөрөнгийг тэнцүү үнэ цэнэ бүхий өөр хөрөнгөөр орлуулан солих боломжтой гэсэн утгыг илэрхийлнэ (тухайлбал 100 төгрөгийг өөр 100 төгрөгийн дэвсгэртээр сольж болдог). Харин “Non-fungible” гэдэг нь өөр хөрөнгөөр “солих боломжгүй”, орлуулшгүй, өвөрмөц хөрөнгийг хэлнэ. Товчхондоо NFT бол тухайлсан бодит эсвэл дижитал (дижитал уран бүтээл, дуу хөгжим, газар, г.м.) хөрөнгийн эзэмшлийг батлах дахин давтагдашгүй токен юм.

Зах зээлийн тойм

NFT зах зээлийн тэсрэлт нь хөрөнгө оруулалтын салбар болон технологийн салбарыг холбосон шинэлэг үзэгдэл болсон. Цахим шилжилт эрчтэй хийгдэж буй өнөө үед блокчэйн технологид суурилсан “Virtual asset” буюу “Виртуал хөрөнгө” дэлхий нийтийн анхаарлыг ихээхэн татах болоод байна. Тэгвэл үүний нэгэн том жишээ болох NFT нь технологи болон урлагийн хослол бүхий үнэ цэнийг бүтээгч хөрөнгө юм.

Зах зээлийн зарим сонирхолтой тоо баримтуудаас дурьдвал:

- Анхны NFT 2014 онд гарсан;
- 2021 онд NFT зах зээлд ойролцоогоор 41 тэрбум орчим ам.долларын крипто зарцуулагдсан байна;
- Хамгийн үнэ цэнэтэй NFT 91.8 сая ам.долларын үнэтэй байна;
- NFT арилжаанд хамгийн ихээр оролцдог 5 улс нь Азийн улсууд байна;
- Нэгэн NFT meme 4 сая ам.долларын үнэлгээтэй зарагджээ;
- АНУ-ийн миллениалуудын 23% нь NFT цуглуулдаг байна;
- NFT урлагийн борлуулалтын тоо 2021 онд нэг сарын дотор 1.5 саяас давжээ.
- Дэлхийн хамгийн үнэтэй NFT meme 4 сая ам.долларын үнэлгээтэй зарагдсан байна;
- Элон Маскийн хуучин найз бүсгүй, Граймс мянга гаруй өөрийн NFT-ийг борлуулж 7 сая ам.доллар гаруй борлуулалтын цэвэр орлого олжээ;
- Рэппэр Эминэм өөрийн хамгийн анхны NFT цуглуулгыг 1.78 сая ам.доллаароор худалджээ;
- Твитерийн үүсгэн байгуулагч Жак Дорси өөрийн анхны жиргээгээ NFT форматаар 2.9 сая ам.доллаароор зарсан байна;
- NBA-ийн тамирчин Лэброн Жэймсийн NFT 21.6 сая ам.доллаароор зарагдсан байна.

NFT Урлагийн бүтээлийн салбарт


NFT дээр суурилсан урлагийн бүтээл, цуглуулгын зах зээл нь уламжлалт урлагийн бүтээл, ховор цуглуулгын зах зээлийн хэмжээг гүйцэхэд тун дөхсөн үзүүлэлттэй байна. 2021 оны 4 дүгээр сараас эхлэн NFT урлагийн бүтээлийн борлуулалт эрс өсөж эхэлсэн ба 9 дүгээр сар гэхэд хамгийн дээд цэгтээ хүрч, ганцхан сарын дотор нийт борлуулалт 774 сая ам.доллар болжээ.



Үүнээс хойш урлагийн бүтээлийн NFT борлуулалт сард дунджаар 150 сая ам.доллар болоод байна. Энэ нь NFT зах зээл нь уламжлалт буюу биет урлагийн бүтээлийн худалдааны зах зээлийг гүйцэж түрүүлэхэд улам бүр ойртож байгаад харуулж байна.

NFT зах зээл нь 2022 онд ч мөн адил хүчтэй хэвээр байна гэсэн хүлээлттэй байгаа ба NonFungible.com мэдээлснээр энэ оны эхний сард NFT-ийн борлуулалт аль хэдийн хагас тэрбум ам.долларт хүрсэн байна. Энэхүү борлуулалтад Bored Ape Yacht Club, CryptoPunks NFT цуглуулга, Doodles, the Sandbox, болон Art Blocks зэрэг нь ихээхэн нөлөө үзүүлсэн байна.

Дижитал уран бүтээлч Beeple (aka Mike Winkelmann)-ийн бүтээсэн “Everydays: The First 5000 Days” буюу “Өдөр бүр: Эхний 5000 өдрүүд” гэсэн нэртэй урлагийн бүтээл нь Christies дээрх дуудлага худалдаагаар 69.3 сая ам.долларын үнэлгээтэй зарагдсан байна.



Видео тоглоомын NFT зах зээл

NFT арилжааны хэмжээ огцом өсөхөд нөлөөлж буй гол хүчин зүйлсийн нэг нь видео тоглоомын NFT-ний нэр хүнд өсөж буй явдал юм. Тоглоомын эд зүйлс 2021 оны 3-р улирлын байдлаар нийт 2.3 тэрбум ам.долларын арилжааны дүнтэй байсан нь нийт NFT арилжааны 22%-ийг эзэлж байна.

Тоглоомын салбарт NFT технологийн эхлэл нь “виртуал муур цуглуулдаг” CryptoKitties тоглоом байсан ба энд тоглогч хоёр NFT бүхий муураас өөр NFT муурыг бүтээж худалддаг байна. CryptoKitties тоглоом олон нийтийг шуугиулснаар бусад тоглоом хөгжүүлэгч компаниуд энэ зах зээлд цаг алдалгүй нэвтэрч, Axie Infinity (долоо хоногийн 1.8 сая ам.долларын орлоготой Ethereum-д суурилсан тоглоом), F1 Delta Time (долоо хоногийн 1 сая ам.долларын орлоготой) зэрэг тоглоомуудыг зах зээлд нэвтрүүлжээ.

Санхүүгийн хураангуй*

Бид уг хөрөнгө оруулалтын өгөөж, зардал, орлогын төсөөллийг доорх хүснэгтэд тусгалаа. Энэхүү NFT Багц нь сард дунджаар 10%-ийн өгөөжтэй байна гэж үзэж байгаа ба татан төвлөрүүлэх хөрөнгийн тодорхой хувийг мөнгөн тэмдэгт/крипто валют хэлбэрээр хөрвөх чадварын нөөц болгож, тус нөөцийг арилжааны шимтгэл, ханшийн алдагдал, хөрвүүлгийн зөрүү, нэгжийг буцаан худалдан авах болон бусад гэнэтийн зардлуудад ашиглах болно. Хөрөнгө оруулалтын хугацаа дуусаж багцыг зах зээлд худалдсаны дараа нөөцийн үлдэгдлийг хөрөнгө оруулагчдад хуваарилна.

Багцын хэмжээ	\$25,500.00
Хөрвөх чадварын нөөц (сарын үлдэгдэл)	\$4,500.00
Нийт татан төвлөрүүлэх хөрөн	\$30,000.00
Зардлын задаргаа:	\$11,060.54
Арилжааны шимтгэл	\$8,746.13
Арилжааны шимтгэл (3%)	\$2,314.41
Жилийн нийлмэл өгөөж (CAGR)	94.98%
Сарын нийлмэл өгөөж	5.72%

Тэмдэглэл:

Сар бүр санд нэмэлт хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх ба үүний 80% нь NFT багцад, үлдсэн 20% нь хөрвөх чадварын нөөцөд (сангийн хэмжээ болон гүйцэтгэлээс хамаарч өөрчлөгдөх боломжтой) нэмэгдэх болно.

Цэвэр хөрөнгийн үнэлгээг сар бүрийн эцэст тодорхойлох ба нэмэлт хөрөнгө оруулалтын үнийг нь дараа сарын эхний долоо хоногт цэвэр хөрөнгийн үнэлгээн дээр нэмэгдэнэ.

Гүйлгээний зардал, сангийн бусад зардал болон валютын алдагдал нь санхүүгийн төсөөлөлд заасан хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд хөрвөх чадварын нөөцөөс тухайн алдагдлыг хаана.

*Хавсралт 1-ээс дэлгэрэнгүй тооцооллыг үзнэ үү.

3 | Хөрөнгө оруулалтын процесс

ОРДА:

-Судалгаа хийх;
-Холбогдох бичиг баримт бэлтгэх;
-Цахим маркетинг;
-Онлайн танилцуулга

ХО-ын формыг хүлээн авах

Хөрөнгө оруулалтын баримт, бичиг бэлдэх

Төлбөрийн нэхэмжлэх илгээх

Төлбөрөө шилжүүлэн баталгаажуулж гэрээг илгээх

Хөрөнгө оруулалт баталгаажсаныг ХОруулагчид мэдэгдэх

Хөрөнгө оруулагч:

-ХО-ын танилцуулга, проспектуар уншиж танилцах;
-Танилцуулга видеог үзэх;
-Бусад шаардлагатай мэдээлэлтэй танилцах

Хөрөнгө оруулалт хийх хэмжээгээ тодорхойлох;

ХО-ын форм бөглөн захиалга өгөх;

Төлбөрийн арга хэрэгслээ сонгох:
-Мөнгөн дэвсгэртээр;
-Криптовалютаар.

Мөнгөн тэмдэгт
Компанийн Монгол дахь банкны дансруу шилжүүлэх (MNT эсвэл USD)

Крипто
Криптовалютыг компанийн цахим хэтэвчруу шилжүүлэх (Stablecoin)

Гэрээтэй уншиж танилцаад гарын үсэг зурж баталгаажуулах

Хөрөнгө оруулалтаасаа хэрхэн гарах вэ?

1. Хэрэв та өөрийн хөрөнгө оруулалтыг зарахыг хүсвэл сар бүрийн эхний долоо хоногт ОРДА-д буцаан худалдах боломжтой. Нэгжийн үнэ нь өмнөх сарын эцсийн цэвэр хөрөнгийн үнэлгээгээр тодорхойлогдоно. Буцаан худалдан авалтыг хөрвөх чадварын нөөцөөс хийж гүйцэтгэнэ..
2. 1 жилийн дараа хөрөнгө оруулагчдын санал хураалтаар хөрөнгө оруулалтын хугацааг сунгахгүй тохиолдолд багцыг татан буулгаж орлогыг хувь тэнцүүлэн хуваарилна. Олонхийн саналаар сунгах болсон тохиолдолд ч хөрөнгө оруулагч өөрийн хүслээр хөрөнгө оруулалтаас гарах боломжтой.

Үйл ажиллагааны процесс ба бидний үйлчилгээ

1. Багцын хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох;
2. Хөрөнгө оруулалтын хугацааг тогтоох - Хамгийн багадаа 1 жил (Хөрөнгө оруулагчдын олонхын саналаар сунгах эсэхийг шийдвэрлэнэ);
3. Зардал болон хөрөнгө оруулалтын тооцоог хийх;
4. Проспектус, танилцуулга бэлтгэн хөрөнгө оруулалтын бэлтгэл ажлуудыг ханган, хөрөнгө оруулагч нарт хаалттай хүрээнд санал болгон санхүүжилт татан төвлөрүүлэх;
5. NFT санг бүрдүүлэх;
6. Багцыг удирдах, хяналт тавих;
7. Тогтмол тайлан мэдээг бэлтгэн хүргүүлэх.

4

Хууль эрх зүйн орчин болон эрсдэлийн менежмент

Хууль эрх зүй татварын орчин

Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд бидний санал болгож буй хөрөнгө оруулалттай (NFT) холбоотой тодорхой зохицуулалт хараахан байхгүй эсвэл дутмаг байдаг тул бид ОРДА дижитал ассет ХХК-ийн хэрэгжүүлэх эзэмшил, хөрөнгийн хяналтад үндэслэн NFT багцад хөрөнгө оруулах боломжийг санал болгож байна. Уг хөрөнгө оруулалтын өмчлөл болон харилцааг талууд хоорондын буюу хөрөнгө оруулагч болон "ОРДА дижитал ассет" ХХК-ийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулах ба NFT худалдан авах зориулалт бүхий хөрөнгө оруулалт байна.

Татвар

Холбогдох NFT-д худалдан авалт болон хөрөнгө оруулалтын өгөөж болон тодорхой татвар ногдуулах шаардлагатай үед болон/ эсвэл NFT гаргагчийг татварын оршин суугч гэж үздэг бол тухайн холбогдох улсын хууль тогтоомж, түүнчлэн Монгол улсын харьяалалын дагуу татвар ногдуулж болно.

NFT гэх мэт зарим санхүүгийн тодорхой хэрэглүүртэй холбоотой бусад улсын тодорхой хууль эрх зүйн зохицуулалтаас хамааран АНУ орох боловч түүгээр хязгаарлагдахгүйгээр Монгол Улсаас бусад орны буюу гадаадын иргэдэд хөрөнгө оруулалтын ногдол ашгийг энд зааснаас бусад хэлбэрээр хуваарилж болохыг анхаарна уу.

Анхааруулга

Энэхүү танилцуулга нь хууль ёсны хүчин төгөлдөр үүрэг эсвэл хариуцлага хүлээлгэх баримт бичиг биш бөгөөд энд дурдсан агуулга нь зөвхөн хөрөнгө оруулалтын боломжийн талаар боломжит хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх зорилготой болно.

NFT нь дижитал валют, үнэт цаас, таваарын бүтээгдэхүүн эсвэл бусад төрлийн санхүүгийн хэрэгсэл биш бөгөөд зах зээл нь өөрөө тогтворгүй зах зээл гэдгийг анхаарах хэрэгтэй.

Хөрөнгө оруулагчид нь зөвхөн өөрийн нэрийн өмнөөс төлөөлөн шийдвэр гаргах болохыг анхаарна уу.

Хөрөнгө оруулалт нь буурч бас өсөх боломжтой. Зах зээл өсөлттэй байх үед богино хугацааны эсвэл урт хугацааны тодорхой хэлбэлзэл үргэлж үүсч болно. Иймд бид хөрөнгө оруулагч өөрийн оруулсан бүх мөнгөө буцааж авах баталгааг өгөх боломжгүй юм. Орда энэ танилцуулгаар дамжуулан хөрөнгө оруулалтын гүйцэтгэл эсвэл орлого олох баталгааг өгөхгүй бөгөөд өмнөх гүйцэтгэл нь ирээдүйн гүйцэтгэлийн баталгаа болохгүй.

Энэхүү танилцуулгад агуулагдах зарим тайлан, тооцоолол, санхүүгийн мэдээлэл нь зөвхөн мэдээллийн зорилгоор хийгдсэн болно. Мөн ирээдүйн санхүүгийн төсөөлөл болон таамаглалуудыг дэвшүүлсэн ба энэ нь уг хөрөнгийн хэтийн төлвийн баталгаа болохгүй болно. Тус ирээдүйн санхүүгийн төсөөлөл болон мэдээлэл нь мэдэгдэж байгаа болон үл мэдэгдэх эрсдэл, тодорхойгүй байдлыг агуулж байгаа нь бидний өгсөн мэдээлэл, тооцоолол бодит үйл явдал, үр дүнгээс зөрүүтэй байж болохыг үгүйсгэх үндэслэл болохгүй.

NFT хадгалалт

Бид MPC (Multi party computation) технологи дээр суурилсан байгууллагуудад зориулсан крипто хэтэвчийг ашиглан NFT болон хөрвөх чадварын нөөцийг крипто валютаар хадгалахаар төлөвлөж байна. MPC технологи нь цахим халдлагад хамгийн ихээр ашиглагддаг хувийн нууц үгийг (private keys) ганцхан компьютерт халдгалахгүй байх боломж бүрдүүлснээр хамгийн өндөр зэрэглэлийн хамгаалалт болж чаддаг.

5 | Манай баг

Үүсгэн байгуулагчид



Гэрэлмаа. Б

CEO & Үүсгэн байгуулагч
Бодлого, Технологи, Бизнес
Инновацийн мастер, UVSQ, France
Математикийн бакалавр, KAIST

- 2021 **ADB** болон **Монгол банк** Зөвлөх
Банкны систем, дижитал банкны дахин төлөвлөлт
- 2015-2021 **Steppe Group** Гүйцэтгэх захирал
Хүн төвтэй санхүү, технологийн компани
- 2019-2021 **AmCham Mongolia** ТУЗ
ICT болон дижитал эдийн засгийн хорооны дарга
- 2013-2014 **OECD** Бодлогын шинжээч
Компанийн засаглал, хөрөнгө оруулалтын орчны
томоохон реформ дээр ажилласан
- 2013-2014 **UVSQ** Инновацийн мастер зэрэг
Сэргээгдэх эрчим хүчний инновациар хэд хэдэн
стартап
- 2008-2013 **KAIST** Бакалаврын зэрэг
Математик болон Менежментийн шинжлэх ухааны
хосолсон бакалаврын зэрэг



Peter Choe

CTO & Үүсгэн байгуулагч
Финтек, CS, Стартап
UPenn CS мастер, NYU бакалавр
KAIST CS Докторын зэрэг. ABD

- 2016-2018 **UPMC** Ахлах системийн инженер
Эрүүл мэндийн үйлчилгээг
цахимжуулах төсөл дээр ажилласан
- 2015-2016 **Seeds** CTO
Barclays Techstars NYC стартапын
хурдасгуур хөтөлбөрийн төгсөгч
- 2010-2012 **atDusk** CEO/Үүсгэн байгуулагч
Судалгаан дээр үндэслэсэн
технологийн төсөл
- 2004-2012 **KAIST** PhD ABD
Томоохон HCI конференсүүдэд оролцсон
(UbiComp, CHI, Mobile HCI and ACM
Multimedia)

Багийн гишүүд



А.Хэрлэнчимэг

CFO
Санхүү, бодлого
Глостерширийн их сургууль,
Англи улс, M.B.A.



Н. Буяндэлгэр

Сангийн менежер
Санхүү, хөрөнгө оруулалт
Азийн их сургууль, Тайвань
Санхүү удирдлага, Бакалавр



Zoljargal A.

Сангийн менежер
Санхүү, хөрөнгө оруулалт
Хандоны Их сургууль, Солонгос
Бизнесийн удирдлага, Бакалавр



Р. Гантөмөр

Санхүүгийн менежер
Санхүү, бодлого
Кангвоны их сургууль, БНСУ
Эдийн засагч, Мастер



П.Пүрэвдулам

Санхүүгийн шинжээч
СЭЗИС
Санхүү удирдлага, Бакалавр



Н. Урин

Санхүүгийн шинжээч
СЭЗИС
Санхүү удирдлага, Бакалавр



Б. Солонго
СОО
Луизианагийн их сургууль, АНУ
Бизнесийн удирдлага, Бакалавр



Б. Хүслэн
Хуулийн зөвлөх
Рэнмин их сургууль, БНХАУ
Хууль, Мастер



Б. Болдтоого
Дадлагажигч
МУИС
Бизнесийн удирдлага, Бакалавр



Баярмаа
Дадлагажигч
Улсаны ШУТИС, БНСУ
Инженер, бизнесийн удирдлага,
Бакалавр



М. Содгэрэл
Хөгжүүлэгч
Нью-Йоркийн их сургууль, Абу Даби
Компьютерийн ШУ, Бакалавр



Nathnael Tsegaye
Хөгжүүлэгч
Нью-Йоркийн их сургууль, Абу Даби
Цахилгааны инженер, Бакалавр



Vipul Bansal
Хөгжүүлэгч
Пунжабын техникийн ИС, Энэтхэг
Мэдээллийн технологи, Мастер



Б. Өгөдэй
Хөгжүүлэгч
Чикагогийн их сургууль, АНУ
Эдийн засаг, Бакалавр

Олон улсын зөвлөх баг



Len Ball
Дижитал шилжилтийн менежмент
Канадын банк санхүү, Стартап
Уилфрид Лориер их сургууль,
Мастер



Sung Won Park
Нью Йоркийн хуульч
JP Morgan Chase, Credit Suisse Санхүүч
NYU Stern,
Санхүү ба мэдээллийн технологи



Charles Latchoumane
Тархи судлал, зан төлвийн
санхүү
KAIST, Мастер, Доктор



Hyukjae Jang
БНСУ, Японы Лайн компанийн ахлах
хөгжүүлэгч
KAIST, Компьютерийн ШУ-ы Доктор



Benny Lau
Хөрөнгө оруулалт, Дойче банк
Прайм брокерийн Ази номхон
далайн бүс хариуцсан захирал



Joshua Foo
Бүсийн захирал, Chainalysis
GovTech Сингапур

6

Түгээмэл асуултууд

- **NFT гэж юу вэ?**

NFT гэдэг нь “non-fungable token буюу орлуулашгүй, цор ганц токен” гэсэн үгний товчлол ба блокчейн технологи дээр баталгааждаг дижитал хөрөнгө юм. Уг хөрөнгөд урлагийн бүтээл, хөгжим эсвэл өвөрмөц аватар гэх мэт цахим тоглоомын хөрөнгө багтдаг. Энэ бүгд өвөрмөц бөгөөд дахин давтагдашгүй учраас NFT-ийг цуглуулах гол хүчин зүйл болоод байна.

- **NFT-ийг юу үнэ цэнэтэй болгодог вэ?**

NFT-ийн үнэ цэнэ нь түүний төлөөлж буй өмч/хөрөнгөөс бий болдог ба энэ нь ерөнхийдөө дижитал ертөнцөд орших урлагийн бүтээлийн анхны хувь эсвэл дижитал дурсгалт зүйл байна гэсэн үг юм. NFT нь өөрөө дижитал шинж чанарыг агуулсан байх албагүй, харин блокчейн дээрх байршлыг зааж өгдөг. Тоглолтын тасалбар эсвэл биет эд хөрөнгийн гэрчилгээтэй адил NFT нь төлөөлж буй зүйлийнхээ өвөрмөц үнэ цэнийг илэрхийлдэг.

- **Төлбөрөө хэрхэн төлөх вэ /Төлбөрийн хэлбэр/?**

Бид хөрөнгө оруулагчийн сонголтоос хамааран хоёр өөр төрлийн төлбөрийн хэлбэрийг санал болгож байна. Үүнд:

- **Крипто валют:** Хөрөнгө оруулагч хэрэв хүсвэл өөрийн крипто хэтэвчээр дамжуулан төлбөрийг крипто валютаар шилжүүлэх боломжтой ба энэ тохиолдолд бид зөвхөн USDC эсвэл USDT гэх мэт тогтвортой криптог (Stable coin) хүлээн авах болно. Хөрөнгө оруулагч төлбөр шилжүүлэх крипто валютаа сонгон “Орда дижитал ассет” ХХК-ийн крипто хэтэвчрүү шилжүүлэх ба шилжүүлэг хийж буй өдрийн ханшаар бодогдох болно.
- **Мөнгөн тэмдэгт:** Бид мөн хөрөнгө оруулагчийн сонголт дээр үндэслэн мөнгөн тэмдэгтээр төлбөр шилжүүлэх боломжийг олгож байна. Энэ тохиолдолд Орда дижитал ассет ХХК-ийн арилжааны банк дахь данс руу шилжүүлэх ба валютын ханш нь Орда дижитал ассет ХХК-аас тогтоосон тогтмол ханш байна.

7

Хөрөнгө оруулалтын анхааруулга

“ОРДА Вэлф тэк” ХХК (цаашид холбоо хамааралтай бүх компаниудыг “ОРДА” гэх) нь гар утасны аппликейшн (цаашид “платформ” эсвэл “апп” гэх) дээр суурилсан хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг.

Бид платформоороо дамжуулан уламжлалт бус хөрөнгө оруулалтад хөрөнгийг хэсэгчилэн, эсвэл бүхэлд нь өмчлөх замаар оролцох боломжийг санал болгодог (цаашид “хөрөнгө оруулалт” гэх). Хөрөнгө оруулалтыг анхдагч болон хоёрдогч байдлаар платформ дээр санал болгоно. Энэхүү анхааруулгад манай платформоор дамжуулан үйлчилгээ авахтай холбоотой эрсдэл болон хөрөнгө оруулагч нарын зайлшгүй анхаарах ёстой зүйлсийг багтаасан болно.

Өнгөрсөн үеийн гүйцэтгэл ирээдүйн талаар ямар нэг баталгаа болохгүй бөгөөд хөрөнгө оруулагч өөрийн мөнгийг алдах эрсдэлтэй. Хөрөнгө оруулалтын төрөлжүүлэлт, хөрөнгийн хуваарилалт хийснээр ашиг олох, эсвэл алдагдал хүлээхгүй гэсэн баталгаа биш юм. Хөрөнгө оруулалтын аливаа шийдвэр тухайн хүний өөрийн зорилго, хугацаа, эрсдэл даах чадвар дээр үндэслэх ёстой.

ОРДА нь платформ дээр тавигдсан, эсвэл хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн ямар нэг хөрөнгө оруулалтын материал, танилцуулга, проспектус дээр дурьдсан аливаа хөрөнгийн багц, тоон мэдээллүүд нь ирээдүйд төсөөлсний дагуу явагдах, эсвэл үр өгөөжтэй байх талаар ямар ч амлалт, баталгаа гаргахгүй болно. Платформ дээрх бусад хөрөнгө оруулагч нарын хүртсэн өгөөжийг, эсвэл түүнтэй харьцуулахуйц ямар нэг хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг өөр бусад хөрөнгө оруулагч ирээдүйд хүртэнэ гэсэн үг биш юм.

Платформ дээрх хөрөнгө оруулалтууд ирээдүйд төлөвлөсөн бизнесийн зорилгоо биелүүлэх, хугацааны эцэст хөрөнгө зарагдах эсэх дээр ОРДА ямар нэг баталгаа гаргахгүй.

Хөрөнгө оруулагч нар өөрсдийн судалгааг хийж, Платформ дээрх тооцоолол, таамаглалд дангаар нь итгэж болохгүй бөгөөд бид таныг өөрн санхүүгийн зөвлөх, хуульч, нягтлан бодогч болон тухайн хөрөнгө оруулалтын эрсдэлийн талаар танд зөвлөж чадах ямар нэг мэргэжлийн хүнээс тусламж авч, ярилцахыг зөвлөж байна.

Үнийн трэнд болон бусад түүхэн дата, мэдээллүүд зөвхөн харьцуулсан загварчлалын зорилгоор ашиглагдсан болно. Гарч болох шимтгэл, зардлууд болон бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр бодит өгөөж, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл нь Платформ дээр төсөөлсөн дүнгээс зөрүүтэй байж болно.

Хөрөнгө оруулалтын хөрөнгө бүр онцгой бөгөөд өөрсдийн гүйцэтгэл, эрсдэл, ханшийн савалгаатай байдаг тул тухайн хөрөнгийн гүйцэтгэлийг өөр бусад хөрөнгөтэй шууд харьцуулах нь зохимжгүй гэдгийг анхаарна уу.

ИРЭЭДҮЙ ХЭЗЭЭ Ч ӨНГӨРСӨНТЭЙ ИЖИЛ БАЙДАГГҮЙ. ӨМНӨХ ӨГӨӨЖИЙН ХЭМЖЭЭ НЬ ИРЭЭДҮЙД ТИЙМ ДҮНГЭЭР ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭН ӨСНӨ, ЭСВЭЛ ЯМАР НЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ ОЛНО ГЭСЭН ҮГ БИШ. ХӨРӨНГӨ ОРУУЛЖ БУЙ ҮЙЛДЭЛ БҮРТЭЭ ТА ӨӨРИЙН ОРУУЛСАН ХӨРӨНГИЙГ ХЭСЭГЧЛЭН ЭСВЭЛ БҮХЭЛД НЬ АЛДАХ ЭРСДЭЛ ХҮЛЭЭЖ БУЙГАА АНХААРНА УУ.

Хөрөнгө оруулалтын эрсдэлүүд

Платформоор дамжуулан хөрөнгө оруулах нь өндөр эрсдэлтэй. Ямар нэг хөрөнгөд хөрөнгө оруулахаасаа өмнө проспектус, холбоотой татвар, зардлууд, бизнесийн болон санхүүгийн дүн шинжилгээ, танилцуулгыг анхааралтай уншиж, хянана уу. Мөн өөрийн нягтлан бодогч, хуульч эсвэл бусад зөвлөгөө өгөх боломжтой хүмүүстэйгээ урьдчилан зөвлөлдсөний үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна. Хөрөнгө оруулалтын хүрээнд дараах болон бусад эрсдэлүүд гаргах боломжтой:

- **Нэгж эрхээ буцаан зарж чадахгүй байх эрсдэл.** Платформоор санал болгож буй үнэт цааснууд нээлттэй зах зээл дээр арилжаалагддаггүй. ОРДА арилжааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэхээр хичээн ажиллаж байгаа ч, тэр нь үргэлж амжилттай болно гэсэн баталгаагүй юм. Тиймээс хөрөнгө оруулагч нар өөрийн эзэмшиж буй нэгж эрх, үнэт цаасыг эргүүлэн зарах зах зээл хөрвөх чадвар маш бага, хязгаарлагдмал, мөн зарахтай холбоотой нэмэлт зардлууд гарч болзошгүй гэдгийг анхаарах нь зүйтэй.
- **Хөрөнгийг алдагдалтайгаар зарах эрсдэл.** Хөрөнгө оруулсан хөрөнгийн үнэ цэнэ анх авсан дүнгээс доошлох магадлалтай бөгөөд хөрөнгө оруулагч нар өөрийн оруулсан хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь алдах эрсдэлтэй. Мөн хөрөнгийн үнэ цэнэ өссөн ч өссөн дүн нь гаргасан зардлуудыг нөхөж барахгүй байх эрсдэлтэй.
- **Хөрвөх чадварын эрсдэл.** Уламжлалт бус хөрөнгийн суурь шинж чанар нь хөрвөх эрсдэл бага байх бөгөөд бидний зүгээс дараагийн худалдан авагч хүссэн үнийн дүнгээр эсвэл хүссэн хугацаанд гарч ирнэ гэсэн баталгаа гаргахгүй болно.
- **Уламжлалт бус хөрөнгө оруулалттай холбоотой эрсдэлүүд.** Энэхүү эрсдэлүүдэд (i) хөрөнгийн жинхэнэ эсэх болон үүсэл гаралтай холбоотой маргаан, (ii) хөрөнгийн буруу хадгалалт, чанаргүй үйлдвэрлэл, осол, хулгай, байгалийн гамшиг, гал, болон бусад гадны хүчин зүйлсээс үүдэлтэй хохирол учрах (iii) өмчлөлтэй холбоотой хуулийн маргааны эрсдэлүүд, (iv) зах зээлийн эрсдэлүүд, (v) эдийн засгийн эрсдэлүүд (vi) залилангийн эрсдэлүүд болон бусад эрсдэлүүд орно. Бид платформ дээр санал болгох бүх хөрөнгүүдийг даатгалд хамруулахаар хичээж ажиллах ч гэсэн даатгалаар бүх эрсдэлүүдээс хамгаалах эсвэл бүх хөрөнгүүд даатгалд хамруулах боломжтой байна гэсэн амлалт гаргах боломжгүй юм.
- **Зах зээлийн трэндтэй холбоотой эрсдэлүүд.** Цуглуулагч, хөрөнгө оруулагч нарын дунд нэр хүнд өссөнөөс үүдсэн трэндийн дагуу хөрөнгийн үнэ цэн богино хугацаанд, эсвэл түр зуур өсөөд эргээд маш хурдан унах магадлалтай. Энэ төрлийн трэндийг таамаглахад бэрх бөгөөд хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм.

Хавсралт - 1. Санхүүгийн тооцоолол

Санхүүгийн төсөөлөл				
	Q1	Q2	Q3	Q4
Нэгжийн тоо хэмжээ /эхний үлдэгдэл/	4,700	6,300	8,100	9,900
Сар бүрийн нэмэлт хөрөнгө оруулалт	400	600	600	600
Нэгжийн тоо хэмжээ /эцсийн үлдэгдэл/	5,100	6,900	8,700	10,500
PPS	59	60	60	60
Нэмэлт хөрөнгө оруулалт /ам.доллар/	7,731	12,000	12,000	12,000
Багцад нэмэгдэх	6,185	9,600	9,600	9,600
Нөөцөд нэмэгдэх	1,546	2,400	2,400	2,400
Хөрөнгийн өсөлтийн хувь	30%	30%	30%	30%
Багцын нэмэгдэл ХО	6,185	9,600	9,600	9,600
AUM ³ /эхний үлдэгдэл/	93,872	156,460	240,024	351,248
AUM /эцсийн үлдэгдэл/	103,260	172,106	264,026	386,372
Менежментийн шимтгэл	258	430	660	966
Цэвэр хөрөнгийн үнэлгээ	103,002	171,675	263,366	385,406
Нэгжийн цэвэр үнэлгээ	60	74	91	110
Өгөөж	8.3%	21.2%	20.1%	19.9%
Нэгжид ноогдох ногдол ашиг (хуваарилалтын зардын өмнө)	2	14	31	50
НА-ийн дараах нэгжийн цэвэр үнэлгээ	59	60	60	60
Хөрвөх чадварын нөөц /эхний үлдэгдэл/	12,500	13,500	13,500	13,500
Гүйлгээний зардал /хамгийн их/	1,546	2,400	2,400	2,400
Нөөцөд нэмэгдэх дүн	1,546	2,400	2,400	2,400
Хөрвөх чадварын нөөц /эцсийн үлдэгдэл/	12,500	13,500	13,500	13,500
Нийлмэл өгөөж (сарын/жилийн)	5.72%		94.98%	

Бидэнтэй холбоо барих:

Утас: +976-75779444

И-мэйл: invest@orda.mn

Вэбсайт: www.orda.mn
